

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2020 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, сумд болон Засаг даргын харьяа хэлтэс, агентлагийн дарга нарт 5 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан. Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг цахимаар зохион байгуулж байна.

Засаг даргын зөвлөлийн хурлыг 1 удаа зохион байгуулж, хурлаар 3 асуудлыг хэлэлцэж, шийдвэрлэсэн. Үүнд: Аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнуулахаар нэр дэвшиж ирсэн иргэдийн материалыг танилцуулж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх нээлттэй 425 дугаар ангийн 3 албан хаагчид олгохоор шийдвэрлэсэн. Мөн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн 2020 оны 1 дүгээр улирлын тайлан, аймгийн Засаг даргын харьяа агентлаг, аймаг сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх журмын төслийг танилцуулж, хэлэлцүүлсэн.

Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын Тамгын газрын нийгмийн сүлжээний хуудсанд нийт 32 удаагийн мэдээллийг нийтэлсэн байна. Чойр хотын ерөнхий төлөвлөгөө, аймгийн Сонгуулийн хороо, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн мэдээллийг иргэдэд хүргэх зорилгоор 3 удаагийн шууд мэдээллийг нийгмийн сүлжээгээр цацсан бөгөөд давхардсан тоогоор нийт 14700 иргэнд хүргэсэн.

2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрөөс 5 дугаар сарын 3-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд цэрэг талтлагын ажил явагдаж, 70 хувийн гүйцэтгэлтэй байна.

“COVID-19” халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд:

2020 оны 4 дүгээр сарын 8-11-ний өдрүүдэд аймгийн нийтийн эзэмшлийн 361383м² талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.

Аймгийн Засаг даргын 2020 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн А/97 дугаар захирамжийн дагуу фитнес, теннис, спиннинг клубуудыг 2020 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл 16:00 цагаас 20:00 цагийн хооронд богиносгосон цагаар ажиллуулж байна. 4 дүгээр сарын 20-ны байдлаар “Фитнес клуб”-д 28 иргэн, “Сансар хайрхан ширээний теннисний клуб”-д 8 иргэн, “XS спиннинг-аэробек клуб”-д 21 иргэн хамрагдаж, дасгалжуулагч, багш нарт аюулгүй ажиллагаа болон эрүүл ахуйн цэвэрлэгээ үйлчилгээний талаар арга зүйн зөвлөгөө, зааварчилгаа өгч байна.

2020 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр орон нутгийн тусгай хамгаалалттай байгалийн цогцолбор газар, иргэдийн бөөгнөрөл үүсэж болзошгүй амралт зугаалгаар зорчдог Чойрын богд уул, Хаялага нуур, Цоорхой рашаан, Боржигин голомт цогцолбор зэрэг газруудад эргүүл хяналт хийж, сурталчилгааны самбар байршуулан, аялал зугаалгаар явж буй 30 иргэнд амны хаалтаа зүүх, бага насны хүүхдүүдийг олон нийтийн газраар дагуулж явахгүй байх, тэндэнд тавих анхаарлаа нэмэгдүүлэх мэдээлэл сэрэмжлүүлгийг өгч, гарын авлага материал тараан ажилласан. Мөн аймгийн үүрэн холбооны операторуудаар дамжуулан аймгийн Онцгой комиссоос чиглэл өгч коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээлэл, уриалгыг орон нутгийн 16456 иргэнд мессеж үйлчилгээгээр хүргэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн А/95 дугаар захирамжийн хүрээнд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй сүм хийдүүдэд урьдчилан сэргийлэх шалгалт хийсэн. Шалгалтаар тусгай зөвшөөрөлтэй 2, зөвшөөрөлгүй 3, тусгай зөвшөөрөл авах хүсэлт хүргүүлсэн 4 сүм, хийд байв. Гэвч дээрх сүм, хийдүүд нь өөрийн гэсэн байргүй, цуглаан явуулдаг байр, танхим нь шаардлага хангахгүй, тухайлсан дүрэм журамгүй, цуглаанд хамрагддаг хүмүүс нь тус шашныхаа урсгал, үйл ажиллагааныхаа талаар мэдлэг мэдээлэл дутмаг, холбогдох баримт бичиг хөтөлдөггүй, бага насны хүүхдүүд эцэг эхтэйгээ

цуглаанд хамрагддаг нь хүүхдийн эрүүл, аюулгүй орчин бүрдээгүй, мөргөл үйлдэгчдийг хооллож, цайлдаг гэх боловч хүнсний бүтээгдэхүүнээ шаардлага хангасан нөхцөлд хадгалаагүй зэрэг нийтлэг зөрчлүүд илэрсэн ба эдгээрийг нягтлах, шаардлага хангаагүй сүм хийдийн үйл ажиллагааг зогсоох хүртэл арга хэмжээ авах талаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд санал бүхий албан бичиг хүргүүлээд байна.

2020 оны 3 дугаар сарын 26-ны өдрөөс аймгийн Нэгдсэн эмнэлэг, Энхтусдэм өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүд 24 цагаар үүрэг гүйцэтгэн, Дорноговь аймгийн Замын-Үүд сумаас Сүмбэр сумын цагдаагийн хяналтын цэгээр дайран өнгөрөх автомашинаар зорчиж буй 3112, хот хоорондын нийтийн тээврийн хэрэгсэл автобусаар зорчиж буй 2621 хүний халууныг үзэж, 2244 зорчигчид коронавирусын халдвараас сэргийлэх гарын авлага тарааж үйлчилсэн байна.

Дэлхийн зөн Бор-Өндөр-1 Олон улсын байгууллагын санхүүжилтээр коронавирус халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, мөн энэхүү хүндрэлтэй нөхцөлд гэр бүлийн нэн шаардлагатай хэрэгцээг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй 48 хүүхдийн гэр бүлд 270000 төгрөгийн мөнгөн тэтгэмжийг олголоо.

Оросын холбооны улс болон Солонгос улсаас ирж Улаанбаатар хотод цэргийн эмнэлэг, Баянбуурал амралтын газар, Дархан-Уул аймгийн АШУУИС-ийн дотуур байранд 21 хоногийн ажиглалтын хугацаа дуусч, гэрийн 14 хоногийн ажиглалтанд шилжсэн 6 иргэн сумын эрүүл мэндийн төвийн эмчийн хяналтанд байна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2020 оны 4 дүгээр сарын Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 1629931.0 мян.төгрөг төвлөрүүлэхээс, 1734825.0 мян.төг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 106.4 хувьтай байна.

Улсын төвлөрсөн төсөвт 262575.0 мян.төг төвлөрүүлэхээс 312239.0 мян.төг төвлөрүүлж гүйцэтгэл 118.9 хувьтай байна.

2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар татвар төлөгч ХК-1, ХХК-302, ББН-5, ЗБН-10, Хоршоо-27 ОНӨҮГ-6, Салбар-70, Хадгаламж зээлийн хоршоо-1, Төсөвт байгууллага-57, ТББ-90, Шашны байгууллага-5, Сан-10, ОНБ-16 бүртгэгдэн нийт хуулийн этгээд 600 болж 0.5 хувиар нэмэгдсэн байна.

Орон нутгийн төсвийн байгууллагуудад 2959357.9 мянган төгрөг, Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 3049230.8 мянган төгрөг, ОНХСанд 83357.8 мянган төгрөгийн зарцуулалтын эрх төсвийн хуваарийн дагуу бүрэн нээгдэж төрийн сангийн гүйлгээ хэвийн явагдаж байна.

Статистикийн чиглэлээр: 2020 оны 3 дугаар сарын нийгэм, эдийн засгийн танилцуулга гаргаж байгууллагын цахим хуудсанд байршуулсан. Хэвлэмэл байдлаар 45 хэрэглэгчид тарааж, цахимаар 150 хэрэглэгчид хүргэсэн.

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэвэр

№	Төрөл	2019.04.24		2020.04.24		Шинээр тогтоолгосон
		Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	
1	Өндөр настан	179	2454737.3	1771	2899650.2	1592
2	Хөгжлийн бэрхшээлтэй	315	280749.5	388	501800.0	73
3	Тэжээгчээ алдсан	131	154449.2	151	145800.0	20
4	Үйлдвэрийн осол	58	26847.9	20	65040.0	-38
	Нийт дүн	683	2334867.9	2330	3612190.2	1647

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж

№	Төрөл	2019.04.24		2020.04.24	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян. төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян. төг/
1	ХЧТА тэтгэмж	378	417500	249	24852.3
2	ЖБА тэтгэмж	79	95132.0	85	119501.0
3	Оршуулга	24	24000.0	18	18000.0
4	ҮОМШӨ-ХЧТА	3	1128.4		
5	Ажилгүйдэл	65	97151.0	71	145300.0
	Нийт дүн	549	227866.1	423	266871,.2

Сайн дурын даатгал:

Сайн дурын даатгалын хамрагдалт	2019.04.24	2020.04.24
Шинээр	69	80
Мөнгө тушаасан	515	499
Тушаасан мөнгөн дүн / мян төг/	72150.0	68370.0

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Эрх зүйн сургалт сурталчилгааны чиглэлээр: 2020 оны 4 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагчдын дунд зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналыг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хэлэлцүүлэгт нийт 25 албан хаагч оролцсон.

Архивын ажлын чиглэлээр: Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 6 хөмрөгийн 100 хадгаламжийн нэгжийн 700 заалт бүхий 5460 хүний нэр, 849 байгууллагын нэр, 2112 газар зүйн нэр, нийт 3355 хуудас баримтыг цахимжуулж, 98 хадгаламжийн нэгжийн 1746 хуудас баримтыг скайнердан оруулсан байна. Архивын баримтаас 19 иргэнд лавлагаа мэдээлэл олгох үйлчилгээ үзүүлсэн.

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан -6
- Иргэний үнэмлэх шинээр олгосон -68
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо- 30
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо-3
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо -2
- Үрчлэлтийн бүртгэлийн тоо-1
- Эцэг тогтоолтын бүртгэлийн тоо -1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо -2

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 0
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 62
- Гэрээний бүртгэл - 28
- Барьцааны гэрээний бүртгэл- 188
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга -8

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 2
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт -5

Архивын чиглэлээр:

- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 46
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар-177-г олгож, нийт 568 иргэнд төрийн үйлчилгээг хүргэсэн.

Цагдаагийн хэлтэс нь: 1 дүгээр улирлын байдлаар иргэд, хуулийн этгээдээс 181 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас 81 буюу 44.7 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 100 буюу 55.3 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байна. Гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл урд оны мөн үетэй харьцуулахад 11-ээр буюу 15.7 хувиар өсч, зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 18-аар буюу 15.2 хувиар, нийт хүлээн авсан гомдол мэдээлэл 7-оор буюу 3.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр: “Хайр өвтгөдөггүй” аяны хүрээнд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор санамж, сэрэмжлүүлгийг 569 иргэнд танилцуулсан. Мөн 22 аж ахуйн нэгж байгууллагуудын мэдээллийн самбарт байршуулсан.

Аймгийн Прокурорын газартай хамтран хулгайлах зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүднээс “Харуул хамгаалалт” арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээний хүрээнд Сүмбэр суманд үйл ажиллагаа явуулж байгаа 55 аж ахуйн нэгж байгууллагын судалгааг гарган, хяналт шалгалтыг зохион байгуулахад харуул хамгаалалттай 5 аж ахуйн нэгж, хяналтын камергүй 1 аж ахуйн нэгж, камер суурилуулсан боловч чанарын шаардлага хангахгүй 45, огт ажиллагаагүй 5 аж ахуйн нэгж байсныг түргэн шуурхай ажиллагаанд оруулах талаар газар дээр нь заавар зөвлөмж өгч ажилласан.

Замын хөдөлгөөнд оролцохдоо машины гэрлээ асааж, аюулт өвчин ойрхон байгааг хүн бүрт сануулж, энх цаг иртэл онц байдлын үеийн дүрмээ биелүүлэхийг сурталчлах зорилгоор зохион байгуулагдаж буй “Бусаддаа сэрэмжлүүлэг өгцгөөе” аяны хүрээнд нийт 156 жолоочид зөвлөмж өгсөн.

Шүүхийн шинжилгээний алба нь: Хэргийн газрын үзлэгт 31 удаа оролцоноос зам тээврийн ослын 11, хулгайлах гэмт хэрэг 4, хүний амь нас эрсэдсэн 4, бусад хэргийн газрын үзлэгт 12 удаа оролцож, хэргийн газраас гарын мөр 6, гутлын мөр 2, тээврийн хэрэгслийн мөр 14, бусад ул мөр, эд мөрийн баримт 49-ийг илрүүлэн бэхжүүлж, хэргийн материалд хавсаргасан. Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 819 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-425 дугаар нээлттэй хорих анги нь: Тайлант хугацаанд шинээр ирсэн 32 хоригдлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулинд заагдсан хоригдлын эрх, үүрэг, Албан хаагчийн аюулгүйн тойрог, Хоригдлын хяналтын хуудас зэрэг сэдвүүдээр 2 удаагийн сургалтанд хамруулж, энгэрийн тэмдэг, хяналтын хуудсыг олгон сэтгэл зүйн сургалтанд хамруулсан. Мөн “Угийн бичиг” хөтлөх сургалтанд хамруулсан.

2020 оны 4 дүгээр сард төлбөрийн 74 гүйцэтгэх баримт бичгээс 29 гүйцэтгэх баримт бичгийн 222561.4 мянган төгрөг, хүүхдийн тэтгэлгийн баримт бичгийг бодитой биелүүлж гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 39.1 хувьтай байна.

Мэргэжлийн хяналтын газар нь: Мэргэжлийн хяналтын байгууллагын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө болон цаг үеийн нөхцөл байдал, иргэдээс ирүүлсэн гомдлын дагуу Эрүүл мэндийн байгууллагад дэмжлэгт хяналтыг 3 объектод, төлөвлөгөөт шалгалт 12, төлөвлөгөөт бус 4, урьдчилан сэргийлэх шалгалт 12, тандалт судалгаа 3, зөвлөн туслах үйлчилгээ 3-ыг тус тус хийж, улсын байцаагчийн зөвлөмж 12, дүгнэлт 15, албан шаардлага 27, акт 1, зөвлөн туслах үйлчилгээ 8, удирдамж 15-ыг боловсруулж хяналт шалгалтад хамрагдах болон хамрагдсан аж, ахуйн нэгж байгууллагуудад хүргүүлэв.

Хүнсний чанар, стандарт, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч нар болон аж ахуй нэгж байгууллага, иргэний хүсэлтээр ирүүлсэн усны 18, гурилан бүтээгдэхүүний 2, хоолны 6, кетчупны 2, ариутгалын бодисны 3, арчдасны 33, бохир усны 1,

хөрсний 1, нийт 65 сорьцод 2-8 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг хийхэд эерэг сорьц 13 илэрсэн.

Онцгой байдлын газар нь: Газрын тосны бүтээгдэхүүн хадгалдаг, борлуулдаг, импортолдог аж ахуй нэгжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Сүмбэр, Баянтал, Шивээговь сумдад үйл ажиллагаа явуулдаг шатахууны нөөцийн агуулах 5, шатахуун борлуулдаг шатахуун түгээх станц 12, ГАЗ борлуулдаг шатахуун түгээх станц 2, нийт 19 хуулийн этгээдэд гүйцэтгэлийн хяналт шалгалт зохион байгуулж, шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтанд гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх, гамшгийн эрсдэлийг бууруулах санд жилийн төсвийн 1.5 хувийг суулгаж гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээнд зарцуулж байх талаар зөвлөж, мэргэжил арга зүйн заавар зөвлөгөө өгсөн.

Хаврын хуурайшилтын улирал эхэлсэнтэй холбогдуулан болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх “Гэр хороолол, аюулгүй айл өрх” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулж байна. Тус арга хэмжээний хүрээнд 2020 оны 4 дүгээр сарын 1-20-ны өдрүүдэд Шивээговь, Баянтал, Сүмбэр сумын гэр хороолол, орон сууцны давхардсан тоогоор 1292 айл өрхөд үзлэг шалгалт зохион байгуулж, 1020 зөрчил илрүүлэн 179 зөрчлийг газар дээр нь арилгуулж, 841 зөрчлийг эргэн шалгах хугацаатай үүрэг чиглэл өгч, 3152 хүнд 2350 ширхэг галын аюулаас урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааны материал тарааж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар заавар зөвлөгөө өгч ажилласан.

Галын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор 8 аж ахуй нэгж, байгууллагад гамшиг осол болон гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж, давхардсан тоогоор гал түймэр гарч болзошгүй зөрчил илрүүлж, шалгалт хийх явцад газар дээр нь 8 зөрчлийг засуулж Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлагыг 6 байгууллагын холбогдох албан тушаалтнуудад хүргүүлсэн.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэл дуусч, 2020 онд төгсөх 176, өмнөх оны 23 төгсөгч бүртгүүлсэн байна.

Боловсролын үнэлгээний төвтэй хамтран элсэлтийн ерөнхий шалгалтын сорилго цахим шалгалтыг зохион байгууллаа. Сорилго шалгалтанд 10 хичээлээр 133 сурагч хамрагдлаа.

Сургууль, цэцэрлэгийн 1-3 сарын хүнсний нөөцийг Аймгийн Засаг даргын 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн А/107 дугаар захирамжийн дагуу амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой 200 өрхийн 721 хүүхдэд тусламжаар олгосон.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр: Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, иргэд, олон нийтийг соён гэгээрүүлэх, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор “Хуулиа мэдье-Хариуцлагаа ухамсарлъя” салбарын хууль сурталчилах сарын аяныг 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөс 5-р сарын 13-ны өдрүүдийн хооронд зохион байгуулж байна. Аяны хүрээнд “Хүүхдийн эрхийн тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль”, “Гэр бүлийн тухай хууль”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль”, “Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль”, “Зөрчлийн тухай хууль”, “Хувь хүний нууцын тухай хууль”, “Байгууллагын нууцын тухай хууль”-иудыг сурталчлах ажлыг цахим мэдээллийн хэрэгслээр дамжуулж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны “Хүүхдийн эрхийг хамгаалах, эсрдэлээс урьдчилан сэргийлэх тухай” 01 албан даалгаврыг хэрэгжүүлэх зорилгоор байгууллагуудын дэргэдэх “Эцэг, эхийн зөвлөл”-өөр дамжуулан төрийн болон төрийн бус

нийт 80 байгууллагын зөвлөлд албан даалгаврыг танилцуулж зөвлөмж, чиглэл хүргүүлж ажилласан.

Соёл, урлагийн чиглэлээр: “Боржигин өв” музей нь 2020 оны 3 дугаар сарын 18-ны өдрөөс 2020 оны 4 дүгээр сарын сарын 18-ны өдрүүдэд музейн цахим үйлчилгээнд төрийн 22 байгууллагын 440 төрийн албан хаагчийг хамруулсан.

Номын сангийн цахим үйлчилгээгээр хүүхэд багачуудад 43 төрлийн Монгол ардын үлгэрийг цахимаар сонирхуулсан бөгөөд нийт 1277 хүүхэд цахимаар үйлчлүүлсэн байна.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Үзүүлэлт	2019 оны 02 сар	2020 оны 02 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	127	126
Гэрийн төрөлт	1	0
Амьд төрсөн хүүхэд	128	127
Амьгүй төрөлт	0	0
Нас баралт	17	18
Эмнэлгийн нас баралт	3	1
Хоног болоогүй нас баралт	0	0
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	2
Эмнэлгээс гарсан хүний тоо	1710	1 370
Амбулаторийн үзлэг	33 017	28 851
Халдварт өвчин	74	28

“Лайфтроник” ХХК-аас аймгийн Нэгдсэн эмнэлэгт иммунологийн бүрэн автомат 78 үзүүлэлтээр шинжилгээ хийдэг, 45сая төгрөгийн өртөг бүхий “Minividas” аппаратыг ашиглалтын гэрээгээр нийлүүлж, лабораторын эмч, лаборант нарт сургалт зохин байгуулан иммунологийн шинжилгээний оношлуур болох зүрхний үйл ажиллагаа үзэх тропонин, бамбайн үйл ажиллагаа үзэх TSH, T3,T4, D vitamin, В вирусийн дархлаажуулалт үздэг үзүүлэлтийн урвалжын хамт хүлээлгэн өгсөн байна.

Хөдөлмөр, халамжийн чиглэлээр: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар зөвлөл 4 дүгээр сарын 3-ны өдөр хуралдан 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэн баталсан.

2018, 2019 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хөтөлбөрийн эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 47 иргэнээс үйл ажиллагааны явцын сарын тайланг хүлээн авсан. Эргэн төлөлтийн хувьд 2020 оны 3 дугаар сард 30 иргэн 4248000 төгрөг, 4 дүгээр сард 23 иргэн 5260000 төгрөгийг тус тус төлж хугацаа хэтэрсэн зээлдэгч байхгүй байна.

2020 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар 64 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 8035060 төгрөгийн хөнгөлөлт, тусламжийн үйлчилгээг хүргэсэн. Мөн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай” хуулийн 26 дугаар зүйлийн дагуу хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжийн мэдээ, мэдээллийг олон нийтийн цахим сүлжээгээр иргэдэд хүргэж ажилласан.

Сумдын “Амьжиргааг дэмжих зөвлөл” нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж Олон нийтийн үйлчилгээнд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдахыг хүссэн иргэдийн өгсөн хүсэлтийн дагуу нөхцөл байдлын үнэлгээ хийж, 4 дүгээр сарын төлөвлөгөөт хугацаанд нийт 5 удаа хуралдсан. Сүмбэр сумын амьжиргааг дэмжих зөвлөл нь Олон нийтийн үйлчилгээнд түшиглэсэн халамжийн үйлчилгээний 11 бүлгийн төсөл болон онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжид хамрагдахаар өргөдөл гаргасан 2 иргэнд, Шивээговь сумын

амьжиргааг дэмжих зөвлөл нь 1 бүлгийн төсөлд тус тус газар дээр нь очиж нөхцөл байдлын үнэлгээ хийж нийт 7 бүлгийн төслийг ирүүлээд байна.

2020 онд Зорилтот өрхийн хөгжил хамгааллыг сайжруулах хүрээнд 81 өрх сонгон, өрхүүдийн хөгжлийн түвшинг айл өрхүүдээр айлчилан нөхцөл байдалтай биечлэн танилцаж өрхийн төлөвлөгөөг өрх тус бүрээр боловсруулсан. Хөгжих өрхийн дэлгэрэнгүй судалгааг нарийвчлан гаргаж, хөдөлмөрийн насны иргэдийг төсөл хөтөлбөрт болон ажлын байранд зуучлах санал болгон ажилласнаар 2 иргэн бүлгийн төсөлд хамрагдаад байна.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Мал, аж ахуйн чиглэлээр: 2020 оны 3 дугаар сарын 30-ний өдрөөс 4 сарын 5-ны өдрүүдэд “Богцтой мэдээлэл” аяны хүрээнд 4, 5, 6 дугаар багийн, Шивээговь сумын 2 дугаар багийн малчидтай уулзах, хаваржилт, мал төллөлтийн байдалтай газар дээр нь танилцах, харилцан мэдээлэл солилцох, зарим төрийн үйлчилгээ үзүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаа, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн талаар мэдээлэл өгөх, сум, багийн түвшинд зохион байгуулж байгаа үйл ажиллагааг танилцуулах ажлыг зохион байгуулсан.

Сумдын өвс тэжээлийн аюулгүйн нөөцөд нийт өвс 23.6тн, тэжээл 7тн байгаа ба Баянтал суманд өвс 2 тн, тэжээл 7тн, Сүмбэр суманд өвс 18тн, Шивээговь суманд өвс 3.6тн байна.

Аймаг дундын Малх отрын бүсэд Дундговь, Төв, Өвөрхангай, Говьсүмбэр аймгийн нийт 110.0 мян.толгой мал өвөлжсөн. Сүмбэр, Баянтал суманд нийт 30 гаруй отрын айлын 32.5 мян.мал, Шивээговь суманд отрын 6 айлын 7000 гаруй мал хаваржиж байна.

Мал төллөлт, төл бойжилт

/2020.04.16-ны байдлаар/

№	Сумдын нэр	Оны эхний хээлтэгч					
		Бүгд	Ингэ*	Гүү	Үнээ	Хонь	Ямаа
1	Баянтал	32104	57	1721	1052	17570	11704
2	Сүмбэр	156260	258	5628	4341	78174	67859
3	Шивээговь	23500	67	771	929	11194	10539
Нийт дүн		211864	382	8120	6322	106938	90102

№	Сумдын нэр	Төллөвөл зохих хээлтэгч					
		Бүгд	Ингэ*	Гүү	Үнээ	Хонь	Ямаа
1	Баянтал	28209	36	1635	894	15813	9831
2	Сүмбэр	137430	139	5347	3907	70357	57680
3	Шивээговь	18036	35	733	883	8955	7430
		183675	210	7715	5684	95125	74941

Төллөсөн хээлтэгч						Гарсан төл					
Бүгд	Ингэ	Гүү	Үнээ	Хонь	Ямаа	Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
12551	4	60	117	7417	4953	12551	4	60	117	7417	4953
73070	69	336	838	40626	31201	73173	69	336	838	40678	31252

15363	15	36	124	8297	6891	15469	15	36	124	8350	6944
100984	88	432	1079	56340	43045	101193	88	432	1079	56445	43149

Ямааны ноолуурын дундаж гарц тогтоох судалгааны ажил хийгдэж байна. Одоогоор Сүмбэр сумын 5, 6-р баг, Шивээговь суманд тус ажил хийгдсэн байдал.

Сумын нэр	Хамрагдсан малчин өрхийн тоо	Нийт ямааны тоо	Эр ямааны дундаж гарц /гр/	Эм ямааны дундаж гарц /гр/	Борлонгийн дундаж гарц /гр/	Ерөнхий дундаж
Сүмбэр	82	26985	596	436	335	455
Шивээговь	25	8255	618	456	338	471
Дүн	107	35240	593.5	446	336.5	463

Үйлдвэр, худалдаа үйлчилгээний талаар:

Хүнсний чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаа, бараа бүтээгдэхүүний татан авалт хэвийн байгаа бөгөөд, хүнсний бүтээгдэхүүний бодит нөөцийг Сүмбэр сумын 13 цэг, Баянтал сумын 3 цэг, Шивээговь сумын 5 цэгээс тогтоосон. Үүнд: махны нөөц 4 хоногийн, гурил 22 хоногийн, төрөл бүрийн будаа 15 хоногийн, төмс, хүнсний ногооны нөөц 29, элсэн чихэр 26, бусад хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн 3-12 хоногийн нөөцтэй байна.

Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ийг шинэчлэн баталсны дагуу орон нутгийн иргэд аж, ахуйн нэгж, байгууллагуудад мэдээллийг цахимаар хүргэж, гарын авлага бэлтгэн 15 иргэнд тараасан. Жижиг, дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчээр бүртгүүлэх хүсэлт ирүүлсэн 2 аж ахуйн нэгжийг бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчээр бүртгэж, тодорхойлолт олгосон.

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2020 оны 04-р сарын үнийн мэдээ

Зах зээлд худалдаалагдаж буй Үхрийн /ястай/ махны үнэ 500 төгрөгөөр, хонины мах /цул/ 500 төгрөгөөр, адууны мах /цул/ 500 төгрөгөөр, ямааны мах /цул/ 500 төгрөгөөр, төмс 250 төгрөгөөр зарим хүнсний ногооны үнэ өнгөрсөн сараас 50-250 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

№	Бараа бүтээгдэхүүн	Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан	
1	Үхрийн мах	ястай	10000	8500	+500
		цул	12000	11000	-
2	Хонины мах	ястай	8000	7000	
		цул	10000	10000	+500
3	Адууны мах	ястай	8500	7500	
		цул	9000	9000	+500
4	Ямааны мах	ястай	7000	6000	
		цул	9000	9000	+500
5	Тахианы мах	гуя	10500	10000	
		мөч	9800	9000	

6	Лууван	МОНГОЛ	2000	1200	-
		Хятад			
7	Төмс	МОНГОЛ	1250	850	+250
		Хятад			
8	Байцаа	МОНГОЛ	1500	1200	
		Хятад			-
9	Чинжүү	МОНГОЛ			-
		Хятад	6500	5500	
10	Манжин	МОНГОЛ	3800	3200	+50
		Хятад			-
11	Сонгино бөөрөнхий	МОНГОЛ	3000	2500	-
		Хятад	1500	1400	-
12	Улаан лооль	МОНГОЛ	6000	5500	-
13	Өргөст хэмх	МОНГОЛ	8000	6500	-
14	Элсэн чихэр	МОНГОЛ	2100	1600	-
15	Будаа	цагаан будаа задгай кг	2500	2200	+100
		шар будаа слава кг	3500	3000	-
		гурвалжин будаа кг	3800	2200	-
16	Сүү	задгай	2500	2000	-
		сүү ХХК 0,5л			
		сүү ХХК 1л	3200	3050	-
17	Тараг	задгай	2200	2000	-
		сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
18	Талх	Чойр талх	1200	750	-
19	Өндөг	ОХУ	400	330	-
		Монгол	400	300	-
20	Алтан тарианы гурил	задгай дээд	1520	1480	+250
		задгай 1-р зэрэг	1140	1100	+20
		задгай 2-р зэрэг	1000	950	-
		савласан д/дээд /	2400	2300	-
		савласан дээд	2200	2100	-
		савласан 1-р зэрэг	1400	1300	-
21	Ургамлын тос	oleyна	5500	4800	+50
		алтан	3800	3600	-
22	Гоймон	aleyка	1800	1600	-
		а/тариа савхан	1100	950	-

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр: Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас Сум дундын Ойн ангид 9000 ширхэг мөчир /улиас 7100ш, бургас 900ш, сухайн 1000ш,/ болон хүлэмжийн материал /хүлэмжийн нийлэг хальс 3ш, нарны гэрэл бууруулагч 3ш, бороожуулагч хошуу 100ш, манцул 2ш, клип 15ш, бороожуулагч ком хошуу 20ш/, ногоон байгууламжийн усалгааны авто машинд 2 ширхэг аккумулятор авч өгч үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлсэн байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөтэй ажилладаг 11 аж ахуйн нэгж байгууллагын 2020 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан баталж, 2019 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан 2 аж ахуйн нэгжид Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчаар нийт 1000.0 /нэг сая/ төгрөгийн мөнгөн торгуулийн арга хэмжээ авахуулаад байна.

Мод үржүүлгийн газрын бойжуулах талбайг 9000 мөчрийн суулгац тарихад бэлтгэн хагалж, 25 тонны ус нөөцлөх сав Соёл амралтын хүрээлэнгийн 3 худгийг будаж, өнгө үзэмжийг сайжруулсан.

Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс 4 дүгээр сард 8 хугацааны мэдээг нийт 240, климат агро дундаж хөдөө аж ахуйн тойм болон 10 хоногийн тойм мэдээг нийт 3, сарын тойм мэдээг 1 удаа тус тус төв станцад дамжуулсан.

Энэ сард агаар бохирдуулагч элементүүд болох азотын давхар исэл (NO_2), хүхэрлэг хийн давхар ислийг (SO_2) хоногт 3 удаа нийт 39 сорьцыг авч шинжилгээ хийсэн ба шинжилгээний дундаж дүнгээр азотын давхар исэл (NO_2) $0.016\text{мкг}\text{м}^3$, сарын хүлцэх агууламж нь $0.050\text{мкг}\text{м}^3$, хүхэрлэг хийн давхар исэл (SO_2) $0.018\text{мкг}\text{м}^3$ байгаа нь хүлцэх агууламжаас даваагүй байна.

Тээвэр, авто замын талаар: Тээврийн хэрэгслийн техникийн үзлэг оношилгоонд 2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 538 тээврийн хэрэгсэл хамрагдсан бөгөөд 2020 оны өссөн дүнгээр 1338 тээврийн хэрэгсэл хамрагдсан байна.

Тайлант хугацаанд хот хооронд 496 иргэн зорчиж, 34 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийгдэн, ачаа тээвэрлэлтийн 300 замын хуудас олгосон байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар: Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Төсвийн тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу Кадастрын нэгдсэн системийг Татварын удирдлагын нэгдсэн системтэй холбож дундын мэдээллийн санг байгуулсан. Уг дундын мэдээллийн сангаар дамжуулан 2020 оноос газрын төлбөрийг аймгийн Татварын хэлтэс хурааж байхаар өөрчлөлт орсонтой холбогдуулан 2020 онд 2051 нэгж талбарт төлбөрийн нэхэмжлэхийг үүсгэн татварын мэдээлийн санд илгээсэн байна.

Газрын үнэлгээний системийг нэвтрүүлэхтэй холбоотойгоор бэлтгэл ажлыг хангаж, газрын цахим биржийн системд 2018, 2019 оны газрын зах зээлийн үнийн мэдээг 100% оруулсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2020 онд дамжин хэрэгжиж байгаа 100 ортой Нэгдсэн эмнэлгийн барилгын ажил 50 хувьтай, Сүмбэр сумын 640 хүүхдийн суудалтай сургуулийн барилга угсралтын ажил 40 хувьтай, Сүмбэр сумын 150 хүүхдийн суудалтай цэцэрлэгийн барилга угсралтын ажил 10 хувьтай, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвийн барилга угсралтын ажил 10 хувьтай, Сүмбэр сум, 2-р багийн гэр хорооллыг цэвэр усны шугамд холбох, Тэрэгтийн эх үүсвэрт өргөх станц, цэвэршүүлэх тоног төхөөрөмж тавих ажил 40 хувьтай тус тус хийгдэж байна.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хийгдэж буй Сүмбэр сумын 150 хүүхдийн суудалтай цэцэрлэгийн барилга угсралтын ажил 40 хувьтай хийгдэж байгаа бөгөөд Япон улсын Засгийн газрын “Өвсний үндэс” буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн хөрөнгөөр хийгдэж буй Сүмбэр сумын 1-р цэцэрлэгийн их засварын ажлын гэрээг байгуулаад байна.

АОНХСангийн хөрөнгөөр хийгдэж буй Сүмбэр сумын 6 дугаар байрны фасад засварын ажил 20 хувьтай хийгдэж байна.

Худалдан авах ажиллагааны талаар: Улсын төсвийн хөрөнгөөр 8 ажил хийгдэхээр төлөвлөгөөнд тусгагдсанаас 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар 6 ажлын тендер шалгаруулалтыг зарлаж, 1 ажлын нээлт хийх хугацаа болоогүй, 5 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.

Орон нутгийн хөгжлийн сан, Орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 16 ажил хийгдэхээр төлөвлөгөөнд тусгагдсанаас 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар 9 ажлын тендер шалгаруулалтыг зарлаж, 3 ажлын нээлт хийх хугацаа болоогүй, 6 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан.

Авто замын сангийн хөрөнгөөр 1 ажил хийгдэхээр төлөвлөгөөнд тусгагдсан ба тендер шалгаруулалтыг дахин зарлаад байна.

Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хөрөнгөөр 4 ажил хийгдэхээр тусгагдсаны дагуу 2 ажлын нээлт хийх хугацаа болоогүй, 2 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулсан байна.

Зарлагдсан тендерийн урилгуудыг “Монголын үнэн” сонин, www.tender.gov.mn govisumber.gov.mn сайтуудад тухай бүр нийтэлж, тендер шалгаруулалтын үр дүнг цахим системд оруулан ажиллаж байна.

ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

Баянтал сум: Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд сумын Соёлын төвийн номын сангийн фондыг нэмэгдүүлэхээр Орон нутгийн хөгжлийн сангийн 2594.0 төгрөгөөр шинэ ном хэвлэлээр баяжуулж нийт 122 нэрийн 264 номыг хүлээн авлаа.

Сумын хэмжээнд нийт 18323 мал төллөж, 18191 төл бойжиж байна. Үүнд: ботго 5, унага 95, тугал 130, хурга 10234, ишиг 7727 байна. Том малын зүй бус хоргодол 111 байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд, мэргэжил сонголт, бизнес эрхлэгчдийг дэмжих арга хэмжээ, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн талаар нийт 9 төрлийн 200 гаруй ном, гарын авлагыг багийн Засаг дарга нар, Ахмадын ТББ, төсвийн 4 байгууллагын ажилтан, албан хаагчдад хүргэж, хөтөлбөрт хамрагдах төсөл хүлээн авах зарыг сумын цахим зарын хаяг, мэдээллийн самбараар мэдээллэн ажиллаж байна.

2020 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр сумын төвийн нийтийн эзэмшлийн талбай, орон сууцны байруудын орц, 2 цайны газар, дэлгүүр зэрэг нийт 5000м² талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийсэн.

Шивээговь сум: Сумын “Төрийн албан хаагчдын ажиллах орчин нөхцлийг дээшлүүлэх, иргэдэд чиглэсэн төрийн үйлчилгээг сайжруулах” дэд хөтөлбөрийн хүрээнд Шивээговь сумын ЗДТГ-ын үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцоо - ISO 9001:2015 олон улсын стандартыг нэвтрүүлэхээр “Монголын Менежментийн Зөвлөхүүдийн Холбоо” төрийн бус байгуулагатай 2020 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр гэрээ байгуулан анхан шатны сургалтыг зохион байгууллаа.

Сумын нийтийн эзэмшлийн талбайн ариутгал халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулж, нийт 17 цэгийн 21240м² талбайд ариутгал халдваргүйтгэлийг хийж гүйцэтгэсэн.

Хаврын улиралд дэгддэг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Зоонозын үндэсний төвөөс гаргасан 7 төрлийн мэдээлэл, постерийг иргэдэд хүргэх урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах сэрэмжлүүлэх үүднээс олон нийтийн цахим хэрэгсэлээр мэдээллийг сурталчилан ажиллаж байна.

COVID-19 вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сургууль цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоож, хөл хорио тогтоосонтойгоор ТВ хичээлд хамрагдахгүй байгаа хүүхдүүдийн гэрээр ангийн багшийн хамт айлчилж, шалтгаан нөхцөлийг тодруулсан.

Нийт 15 сурагчийн гэрээр айлчилсан бөгөөд үүнээс санхүүгийн боломж буюу амьдралын боломжгүй 4 сурагч, эцэг эхийн анхаарал халамж сул 7 сурагч, гэртээ цоожлогдон үлддэг 2 өрхийн 9 хүүхдийн нөхцөл байдалтай танилцсан.

Сумын Засаг даргын 2020 оны “Нийтийн их цэвэрлэгээ, ногоон байгууламжийн усалгаа, арчилгаа зохион байгуулах тухай” А/04 дүгээр захирамжийн дагуу бүх нийтийн их

цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулан, сумын төвийн ногоон байгууламжийн хашааг засах, хог хаягдлын түүж цэвэрлэх ажлуудыг давхардсан тоогоор 24 аж ахуй нэгж байгууллагын 120 гаруй ажилтан, албан хаагчид хийж нийт 5 га талбайн 3.2 тн хог хаягдлыг цэвэрлэн төв хогийн цэгт зөөж тээвэрлэсэн.

2020 оны 4 сарын 24-ний өдрийн байдлаар 15881 мал төллөснөөс ингэ 15, гүү 36, үнээ 124, эм хонь 8400, эм ямаа 7200 төллөж, мал төллөлт 87.5 хувьтай байна. Төл бойжилт 99.4 хувьтай. Төлийн хорогдол хурга 40, ишиг 60, том малын зүй бус хорогдол 78, адуу 1, үхэр 2, хонь 32, ямаа 43 байна.

Сүмбэр сум: Дэлхийн зөн Олон улсын байгууллага Бор-Өндөр-1 Орон нутгийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр Сүмбэр сумын зорилтот бүлгийн 230 өрхөд 2 удаа тус бүр 80000 төгрөгийн хүнсний тусламж үзүүлсэн.

Сумын аюулгүй нөөцөд 2019 онд 73 тн буюу 3650 боодол өвс бэлтгэн нөөцөлсөн. Сумын Засаг даргын А/56 тоот захирамжаар ажлын хэсэг байгуулагдан малчин мал бүхий 238 өрхөд 2477 боодол өвсийг хөнгөлттэй үнээр худалдан борлуулсан.

2020 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн байдлаар 55078 эх малаас 55101 мал төллөж, 54258 төл мал бойжиж, 843 төл хорогдсон. Том малын хорогдол 543 байна.

1, 2, 3-р багийн нийтийн эзэмшлийн гудамж талбайд нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулж 36 тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт төвлөрүүлэн, 5300 м кв талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажиллалаа.

2020 оны 3 дугаар сарын 26, 27-ны өдрүүдэд золбин нохой, муур устгалын ажлыг зохион байгуулж 154 нохойг устгасан.